

ГЯЛС БАНК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ НЭЭХ ХҮСЭЛТ /Байгууллага/

1. Байгууллагын мэдээлэл:

Байгууллагын нэр: _____ Регистр №: Байгууллагын утас: _____

2. Үйлчилгээг ашиглах харилцагчийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Регистрийн дугаар	Гар утас	И-мэйл хаяг
1					
2					
3					
4					

3. Үйлчилгээнд бүртгүүлэх дансны мэдээлэл:

1.	<input type="text"/>	2.	<input type="text"/>
3.	<input type="text"/>	4.	<input type="text"/>
5.	<input type="text"/>	6.	<input type="text"/>

4. Үйлчилгээний мэдээлэл:

Гялс банк үйлчилгээний Зөвшөөрөл олгох эрхтэй харилцагч нэвтрэх нууц үгээр, Гүйлгээ хийх эрхтэй харилцагч нэг удаагийн нууц үгээр гүйлгээ хийнэ.

№	Овог нэр	Нэвтрэх нэр	Эрхийн түвшин <input checked="" type="checkbox"/>			Нэг удаагийн нууц үг авах хэлбэр /Гүйлгээ хийх эрхийн хувьд/ <input checked="" type="checkbox"/>	
			Гүйлгээ хийх	Зөвшөөрөл олгох	Лавлах	Васко	Нэг удаагийн нууц үг
1						<input type="checkbox"/> Мессеж	<input type="checkbox"/> Мэйл
2						<input type="checkbox"/> Мессеж	<input type="checkbox"/> Мэйл
3						<input type="checkbox"/> Мессеж	<input type="checkbox"/> Мэйл
4						<input type="checkbox"/> Мессеж	<input type="checkbox"/> Мэйл

Гялс банкинд нэвтрэх нууц үг нь бүртгүүлсэн и-мэйл хаягт илгээгдэнэ.

Энэхүү маягыг үнэн зөв бөглөсөн ба Гялс банк үйлчилгээ үзүүлэх гэрээний заалтуудтай бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсөн болохоо баталж байна.

Байгууллагын эрх бүхий ажилтны гарын үсэг:

1-р гарын үсэг: _____ /...../

Овог нэрээ гаргацтай бичнэ үү

Тамга

2-р гарын үсэг: _____ /...../

Овог нэрээ гаргацтай бичнэ үү

Банкны хэрэгцээнд:

Банкны ажилтны нэр, гарын үсэг: _____ Хүсэлт авсан салбар, Т/төв _____

Харилцагчийн дугаар: _____ Теллер дугаар: _____

Огноо: _____

ГЯЛС БАНК ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ /БАЙГУУЛЛАГА/

201 . . . оны . . . –р сарын . . . -ны өдөр

№

Гялс банк үйлчилгээ /цаашид “Үйлчилгээ” гэх/ үзүүлэх гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн холбогдох зүйл заалтыг тус тус үндэслэн нэг талаас Төрийн банк ХХК /цаашид “Банк” гэх/, нөгөө талаас “Гялс банк үйлчилгээний эрх нээх хүсэлт” бөглөж, Гялс банк үйлчилгээ авах хүсэлт гаргасан тоот регистрийн дугаартай, ХХК /цаашид “Байгууллага”, хамтад нь “Талууд” гэх/ нар дор дурдсан нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ.ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

- 1.1. Гэрээний зорилго нь Банк Байгууллагад Гялс банк үйлчилгээ үзүүлэх, Байгууллага Гялс банк үйлчилгээ ашиглан дансны мэдээлэл авах, бэлэн бус төлбөр тооцоо хийх, хүү, шимтгэл төлөхтэй холбогдон үүсэх харилцаа, талуудын эрх, үүргийг зохицуулахад оршино.
- 1.2. “Гялс банк үйлчилгээний эрх нээх хүсэлт” нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.3. Гялс банк гэж харилцагч банкны Вэб, Смарт аппликейшн, Гар утасны сим-д суусан цэс болон Мессеж зэрэг сувгуудаар дамжуулан төрийн банкны цахим үйлчилгээ авахыг ойлгох ба байгууллагын харилцагч зөвхөн банкны Вэб, Смарт аппликейшн сувгаар дамжуулан үйлчилгээ авах боломжтой байна.

ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 2.1. Байгууллага нь банкны “Үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу шимтгэл, хураамж төлнө.
- 2.2. Байгууллагын дансанд Гялс банкаар үйлчилгээгээр (захирал, нягтлан г.м) хоёроос дээш тооны хүн холбогдох бол тус тусдаа нэвтрэх нэртэй байна.
- 2.3. Гялс банкны үйлчилгээнд Банк нь харилцагчийн хугацаатай хадгаламжийн дансыг гүйлгээ хийх эрхгүйгээр бүртгэж болно.
- 2.4. Гялс банк үйлчилгээг ашиглан хийсэн гүйлгээ нь Улаанбаатарын цагаар тооцогдож, банкны програмын өндөрлөлтөөр дуусгавар болно.
- 2.5. Байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нь байгууллагыг бүрэн төлөөлнө.
- 2.6. Банк нь байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Гялс банк үйлчилгээний бүртгэлд өөрчлөлт оруулж болно.
- 2.7. Гялс банк үйлчилгээгээр хийгдсэн бүхий л төлбөр тооцоо, гүйлгээ нь байгууллагад хамааралтай байх ба байгууллага тэдгээрийг бүрэн хариуцна.
- 2.8. Гялс банк үйлчилгээгээр нэг данснаас хийх өдрийн гүйлгээний дээд хэмжээг “Үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заах ба байгууллага хүсэлт гаргаснаар нэмэгдүүлж болно.
- 2.9. Энэхүү гэрээний нөхцөлд Банкны санаачилгаар өөрчлөлт оруулж болох ба Байгууллагад хуанлийн 30 /гуч/-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу сонин хэвлэл, Банкны вэб хуудсаар дамжуулан мэдэгдэх, заасан хугацаанд Байгууллага гэрээнээс татгалзаагүй тохиолдолд өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

ГУРАВ. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Банк дараах үүргийг хүлээнэ:
 - 3.1.1. Байгууллагад Гялс банк үйлчилгээний талаарх өөрчлөлт, шинэчлэлт, заавар, зөвлөгөөг тухай бүрт зохих сувгуудаар дамжуулан хүргэх;
 - 3.1.2. Байгууллагын данс болон гүйлгээний талаарх мэдээллийг Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, нууцлалыг хадгалах;
 - 3.1.3. Байгууллагын хүсэлтийг үндэслэн Гялс банк үйлчилгээгээр хийгдсэн гүйлгээний баримт, дансны хуулгыг баталгаажуулж, гарын үсэг, тамга тэмдэг дарж өгөх;
 - 3.1.4. Банк өөрийн санаачилгаар үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлөө өөрчлөх бөгөөд энэ тухай харилцагчид мэдэгдэх үүрэгтэй.
- 3.2. Банк дараах эрх эдэлнэ:
 - 3.2.1. Гялс банк үйлчилгээ үзүүлсний шимтгэл, хураамжийг тухай бүр байгууллагын данснаас суутган авах;
 - 3.2.2. Байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан электрон шуудан болон утсаар банктэй холбогдох үед тухайн харилцагчийг танихын тулд асуулт асуух, хариулт авах;
 - 3.2.3. Нэвтрэх нууц үгээ 3 удаа, нууц асуулт хариултаа 10 удаа буруу оруулсан байгууллагын эрх бүхий ажилтны нэвтрэх эрхийг түр хаах;
 - 3.2.4. Байгууллага үйлчилгээний хураамжаа төлөөгүй, програмд ямар нэг хандалт хийлгүй 1 жил болсон тохиолдолд үйлчилгээний эрхийг хаах;
 - 3.2.5. Банк нь мөнгө угаах болон терроризмтай тэмцэх аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор дансаар дамжих санхүүгийн аливаа гүйлгээнд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавина;
 - 3.2.6. Байгууллага нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд холбогдох хариуцлагыг хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд үйлчилгээг түдгэлзүүлэх эрхтэй.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Байгууллага дараах үүрэг хүлээнэ:
 - 4.1.1. Байгууллага нь банкинд хүсэлт гаргахдаа мэдээллээ үнэн зөв өгөх бөгөөд өөрчлөгдсөн тухай бүрт банкны дурын нэгжид мэдэгдэж,

мэдээллээ шинэчлэх;

- 4.1.2. Банкны тухайн үед мөрдөж буй шимтгэл, хураамжийг байгууллагын данснаас суутгуулах буюу дансандаа байршуулах бөгөөд шимтгэл байршуулаагүйн улмаас үйлчилгээ зогссоноос үүсэх хариуцлагыг өөрөө хариуцах;
- 4.1.3. Гүйлгээ хийхдээ мэдээллээ үнэн зөв оруулах, гүйлгээг тухай бүрт шалгаж байх;
- 4.1.4. Үйлчилгээнд ашиглагдах нэвтрэх болон гүйлгээний нууц үгийг програмд нэвтрэмэгцээ солих, бусдад мэдэгдэхгүй байх замаар нууцлалыг бүрэн хариуцах;
- 4.1.5. Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн авч буй дансны мэдээлэл, хийж буй төлбөр тооцоог тухайн байгууллага бүрэн хариуцах;
- 4.1.6. Байгууллага дараах тохиолдолд Банкны нэгж эсхүл харилцагчийн мэдээллийн төв 1800-1881-д заавал мэдэгдэнэ. Үүнд:
 - 4.1.6.1. Васко төхөөрөмжийн хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан;
 - 4.1.6.2. Гялс банк үйлчилгээний нууцлалаа бусдад алдсан тухай мэдсэн даруй;
 - 4.1.6.3. Өөрийн данснаас зөвшөөрөлгүй шилжүүлэг хийгдсэнийг мэдсэн даруйд;
- 4.1.7. Гялс банк үйлчилгээнд хэдэн ч харилцагч бүртгүүлэх боломжтой ба ажлаас чөлөөлөгдсөн, албан тушаал өөрчлөгдсөн ажилтны үйлчилгээний эрхийг банкинд бичгээр хүсэлт гарган тухай бүр хаалгах;
- 4.1.8. Гялс банк үйлчилгээг ашигласны эцэст “Гарах” гэсэн сонголтоор гарч байх ба үйлчилгээний нууцлалтай холбоотой мэдээллээ бусдад алдсан, энэ тухайгаа банкинд мэдэгдээгүйгээс болон мэдэгдэх хүртэлх хугацаанд учирсан аливаа хохирлыг хариуцах.
- 4.1.9. Байгууллага нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” Монгол улсын хуулийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4.2. Байгууллага дараах эрх эдэлнэ:

- 4.2.1. Гялс банк үйлчилгээтэй холбоотой санал, гомдол, хүсэлтийг банкинд гаргах;
- 4.2.3. Үйлчилгээтэй холбоотой үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхээр банкинд хандах;
- 4.2.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг банкнаас шаардах;

ТАВ. ХАРИУЦЛАГА, БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Байгууллагын дансанд нэвтрэх эрхтэй хэрэглэгч тус бүр нууц үгээ өөрчлөх, сэргээх тухай хүсэлтээ банкны сайтаас илгээж болно. Энэ үед банкны програмд бүртгэгдсэн электрон шуудангийн хаягт нууц үг солих идэвхижүүлэх код илгээгдэнэ. Энэхүү кодоор байгууллагын эрх бүхий ажилтан өөрөө нууц үг сэргээнэ.
- 5.2. Байгууллага нь гүйлгээ хийхдээ хүлээн авагчийн данс, нэр болон мөнгөн дүн зэргийг зөрүүтэй оруулсан тохиолдолд банк хариуцлага хүлээхгүй.
- 5.3. Байгууллага Гялс банк үйлчилгээний нууцлалтай холбоотой мэдээллээ бусдад алдсан болон энэ тухайгаа банкинд мэдэгдэх хүртэлх хугацаанд учирсан аливаа хохирлыг банк хариуцахгүй.
- 5.4. Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрчлөгдсөн бол байгууллага тухай бүрт банкинд мэдэгдэж, итгэмжлээ солих шаардлагатай. Итгэмжлэл солигчгүйгээс үүдэн гарсан хохирлыг банк хариуцахгүй.
- 5.5. Байгууллага гүйлгээ хийхдээ васко төхөөрөмж, эсвэл гүйлгээ бүрт нэг удаагийн нууц үгийг ашиглана. Хэрэв васко төхөөрөмжөө алдсан бол нэн даруй банкинд хандаж эрхээ түр хаалгана.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 6.1. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж, аль нэг тал цуцлах санал гаргаснаар дуусгавар болно.
- 6.2. Хуульд заасанчлан дансны гүйлгээг зогсоох тухай эрх бүхий байгууллага банкинд ирүүлсэн аливаа албан бичиг, мэдэгдэл нь энэхүү гэрээг цуцлах бүрэн үндэслэл болно.
- 6.3. Энэхүү гэрээнд гарсан аливаа маргааныг талууд хэлэлцээр хийх замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ. Шаардлагатай тохиолдолд маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.4. Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр нь ижил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Банкийг төлөөлж:

Харилцагчийг төлөөлж:

Банкны ажилтан

Салбар, тооцооны төв: 1-р гарын үсэг:.....

Гарын үсэг, тамга тэмдэг:..... 2-р гарын үсэг:.....

/Тамга/